

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: БӨА-2023/01/НА-СТА-НТГ

Цахим хуудас: www.audit.mn

Баян-Өлгий аймаг.

Өлгий хот

2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazguld @ audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн тайлбар.....	7
Хүснэгт, график, хавсралтын товъёог	8
Дүрслэлийн товъёог	8
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	9
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	9
Аудитын зорилт	9
Аудитын хамарсан хүрээ	9
Аудитын арга зүй.....	10
1.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ	11
1.1.1 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт	11
1.1.2. Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт.....	15
1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ	16
1.2.1 Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөлт	16
1.2.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт	18
1.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт	19
1.2.4 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт	19
1.3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОН ТООНЫ ТӨЛӨВЛӨЛТ	21
1.3.1 Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагуудын орон тооны төлөвлөлт	21
2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	22
2.1.1 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл.....	22
2.1.2 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл	24
2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ	25
2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл.....	25
2.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэл	27
2.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл.....	28
2.2.4 Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагуудын орон тооны гүйцэтгэл	28
2.2.5 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	28
3.1 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР	30
3.2 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин.....	31
ДҮГНЭЛТ:	33
ЗӨВЛӨМЖ:	34

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТатвар	Хувь хүний орлогын албан татвар
АТБӨЯХТ	Авто тээвэр болон өөрөө явах хэрэгсэлийн татвар
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОХСан	Байгаль орчныг хамгаалах сан
СХС	Сум хөгжүүлэх сан
БОХС	Байгаль орчныг хамгаалах сан
ХТА	Хот тохижуулах алба
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДГХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт, график, хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт№1	Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт	11
Хүснэгт №2	Суурь орлогын төлөвлөлт /өмнөх онтой харьцуулахад/	12
Хүснэгт №3	Суурь орлогын төлөвлөлт	13
Хүснэгт №4	Сумуудын малд ногдуулах татварын төлөвлөлт	14
Хүснэгт №5	Төсвийн суурь орлогын төлөвлөлт	15
Хүснэгт №6	Төсвийн нийт орлогын төлөвлөгөө	16
Хүснэгт№7	Орон нутгийн суурь зарлагын төлөвлөгөө	17
Хүснэгт№8	Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт	20
Хүснэгт№9	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	22-23
Хүснэгт №10	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	23-24
Хүснэгт№11	Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл	24
Хүснэгт №12	Нийт төсвийн зарлагын гүйцэтгэл	25-26
Хүснэгт №13	Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгуулгаар харуулбал	27
Хүснэгт №14	Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл	28
Хүснэгт №15	Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл	29

Дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4² дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнэн зөв нэгтгэж тайлагнасан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл
- Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7³-д заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн Баян-Өлгий аймгийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгад үндэслэн нийт 235 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл
- Сумуудын ТТЗ-дын 2022 оны төсвийн гүйцэтгэл
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн 2022 оны гүйцэтгэлийн тайлан
- Аймгийн Засаг даргын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Аймгийн ТЕЗ-ын 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүд
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон бусад холбогдох хэлтсүүдийн албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 20-ныг хүртэл хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

³ Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.

1.1.1 Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 14,586.3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 6,414.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс суурь зарлагад олгох шилжүүлгийг 404.9 сая төгрөгөөр баталжээ. Сангийн яамнаас тус аймгийн 2022 оны орон нутгийн суурь орлогыг 13,467.3 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” ээлжит VI дугаар хуралдааны 51 дүгээр тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 1,474.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 14,941.7 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тус аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 8,776.3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 6,414.3 сая төгрөгөөр, суурь орлогыг 13,407.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” ээлжит VIII дугаар хуралдааны 93 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг анх баталснаас 708.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 15,650.6 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж төлөвлөснийг нэмж тооцоход аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн суурь орлогын нийт төлөвлөгөө 19,900.3 сая төгрөг байна

Хүснэгт №1		Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт					сая төгрөг
№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	Баян-Өлгий аймаг			Аймгийн ОНО-ын төсөв	Анх батлагдсан дүнгээс /өссөн, буурсан/
			2022 он		Тодотгол -1		
А	Б	1	2		3	4	6
	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	МУ-ын 2022 оны төсвийн тухай хууль	Аймгийн ИТХ-ын 2021 оны 12.02-ны 51 дүгээр тогтоол	МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 93 дугаар тогтоол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсаныг нэмсэн дүнгээр	/4-2/
I	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	13,467.4	14,941.7	13,407.3	15,650.6	19,900.2	4,958.5
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,467.4	14,941.7	13,407.3	15,650.6	19,900.2	4,958.5
	СУУРЬ ОРЛОГО	13,467.4	14,941.7	13,407.3	15,147.2	16,193.6	1,251.9
	ТАТВАРЫН ОРЛОГО	12,395.0	13,199.0	12,334.9	13,135.0	14,090.8	891.8
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,072.4	1,742.7	1,072.4	2,012.1	2,102.8	360.1
	СУМУУДААС НЭМЖ БАТАЛСАН					1,551.9	1,551.9
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ				122.4	1,771.5	1,771.5

	АЖИЛЛАГААНААС ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ				381.0	383.2	383.2
II	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	28,053.8	29,528.1	22,183.6	24,426.9	28,676.5	-851.56
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,053.8	29,528.1	22,183.6	24,426.9	28,676.5	-851.56
	УРСГАЛ ЗАРДАЛ	27,153.0	28,627.3	21,282.8	23,526.1	26,717.6	-1,909.66
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,077.2	27,951.4	20,648.0	22,975.8	25,987.5	-1,963.86
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,075.8	675.9	634.8	550.3	730.1	54.20
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	900.8	900.8	900.8	900.8	1,958.9	1,058.10
	УРСГАЛ ТЭНЦЭЛ	-13,685.6	-13,685.5	-7,875.5	-8,378.9	-10,524.0	3,161.54
III	НИЙТ ТЭНЦЭЛ	-14,586.3	-14,586.3	-8,776.3	-8,776.3	-8,776.3	5,810.04

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” ээлжит VI дугаар хуралдааны 51 дүгээр тогтоолоор аймаг, сумын татварын болон татварын бус орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 1,474.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 14,941.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөнд Улсын Их Хурлын тогтоолоор 1 удаа, аймгийн ИТХ-ын тогтоолоор 1 удаа тодотгол хийгдэж өөрчлөлт орсон байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” ээлжит VIII дугаар хуралдааны 93 дугаар тогтоолоор аймаг, сумын татварын болон татварын бус орлогыг анх баталснаас 205.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 15,147.2 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж баталсан дүнг оруулж тооцоход аймаг, сумын татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө Сангийн яамны хянасан дүнгээс 2,726.2 сая төгрөгөөр нэмэгдэж 16,193.6 сая төгрөг болсон байна.

Төсвийн суурь орлогын 14,090.0 сая төгрөгийг татварын орлогоос, 2,102.8 сая төгрөгийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөсөн байна.

Өмнөх онтой харьцуулахад орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 4,134.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс аймгийн төсөвт орох орлого 6,235.5 сая төгрөгөөр буурч, сумуудын төсөвт орох орлого 10,355.2 сая төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт №2 Суурь орлогын төлөвлөлт /өмнөх онтой харьцуулахад/ сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	2021 он	2022 он	Зөрүү
1	Аймгийн төсөвт орох орлого	8,711.50	2476.0	-6,235.5
2	Сумуудын төсөвт орох орлого	3,347.70	13717.7	10,370.0
	Нийт орлого	12,059.20	16,193.7	4,134.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн 2022 оны төсвийн төсөлд тус аудитын газраас “төсвийн төслийг боловсруулахдаа орон нутгийн суурь орлогыг нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн тооцоогүй байна” гэсэн дүгнэлт гаргаж цалин, хөлс түүнтэй адилтгах орлого, торгуулийн орлого, бусад орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээр хэвээр нь төлөвлөж батлах, малын хөлийн татварын талаар аймгийн ТЕЗ-д “Сумуудын ИТХ-д малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, малын албан татвар ногдуулж, сумын төсвийн орлогод төвлөрүүлэх талаар чиглэл өгөх”, ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг 2021 оны гүйцэтгэлийн түвшнээс бууруулахгүйгээр төлөвлөх саналыг хүргүүлсэн.

Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого, торгуулийн орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс 468.6 сая төгрөгөөр илүү, ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс орох орлогыг 2021 оны гүйцэтгэлийн түвшнээс 183.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, малд ногдуулах татварын төлөвлөлт хангалтгүй байна.

Хүснэгт №3 Суурь орлогын төлөвлөлт

сая төгрөгөөр

Орлогын нэр төрөл	МУ-ын 2022 оны төсвийн тухай хууль	Аймгийн ИТХ-ын 2021 оны 12.02-ны 51 дүгээр тогтоол	МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлт	Аймгийн ИТХ-ын 2022 оны 93 дугаар тогтоол	Сумуудын ИТХ-ын тогтоолоор баталсан нэмсэн дүнгээр	Зөрүү	
	a	b	c	d	e	/e-b/	/e-a/
СУУРЬ ОРЛОГО	13,467.4	14,941.7	13,407.3	15,147.2	16,193.6	868.1	2,726.2
УРСГАЛ ОРЛОГО	13,467.4	14,941.7	13,407.3	15,147.2	16,193.6	868.1	2,726.2
ТАТВАРЫН ОРЛОГО	12,395.0	13,199.0	12,334.9	13,135.1	14,090.8	508.0	1,695.8
Орлогын албан татвар	9,900.0	10,046.0	9,839.9	9,982.1	10,298.4	252.4	398.4
ХАОАТатвар	9,900.0	10,046.0	9,839.9	9,982.1	10,298.4	252.4	398.4
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	8,000.0	8,146.0	7,939.9	8,146.0	8,408.5	262.5	408.5
Үйл ажиллагааны орлого	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,010.0	10.0	10.0
Хөрөнгийн орлого	1,550.0	1,550.0	1,550.0	1,550.0	1,555.0	5.0	5.0
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	200.0	200.0	200.0	200.0	240.0	40.0	40.0
ХХОАТатварын буцаан олголт	(850.0)	(850.0)	(850.0)	(913.9)	(915.1)	(65.1)	(65.1)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560.0	560.0	560.0	560.0	560.0	100.0	170.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560.0	560.0	560.0	560.0	560.0	-	-
Хөрөнгийн албан татвар	865.0	935.0	865.0	935.0	1,195.5	50.0	120.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	370.0	370.0	370.0	370.0	420.0	50.0	50.0
Бууны албан татвар	65.0	65.0	65.0	65.0	65.0	-	-
АТӨЯХАТатвар	430.0	500.0	430.0	500.0	500.0	-	70.0
Малд ногдуулах татвар					210.5	210.5	210.5
Бусад татвар, төлбөр, хураамж	390.0	508.0	390.0	508.0	549.0	36.0	154.0
Улсын тэмдэгтийн хураамж	340.0	340.0	340.0	340.0	345.0	5.0	5.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	40.0	40.0	40.0	40.0	60.0	20.0	20.0
Ус бохирдлын төлбөр, хураамж					5.0	5.0	5.0
Хог хягдалын үйлчилгээний хураамж	10.0	128.0	10.0	128.0	139.0	11.0	129.0
Газрын төлбөр	320.0	320.0	320.0	320.0	320.0	-	-
Газрын төлбөр	320.0	320.0	320.0	320.0	320.0	-	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	360.0	830.0	360.0	830.0	999.6	169.6	639.6
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	40.0	40.0	40.0	40.0	48.0	8.0	8.0
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	300.0	770.0	300.0	770.0	931.6	161.6	631.6
Ус, рашаан ашигласны төлбөр	20.0	20.0	20.0	20.0	20.0	-	-
Бусад татвар	-	-	-	-	168.3	168.3	168.3
Бусад татвар					168.3	168.3	168.3
II.Татварын бус орлого	1,072.4	1,742.7	1,072.4	2,012.1	2,102.8	360.1	1,030.4
Хүүгийн орлого					736.0	736.0	736.0
Торгуулийн орлого	510.0	730.0	510.0	730.0	8.8	(721.3)	(501.3)
Төсөвт газрын өөрийн орлого	52.4	72.4	52.4			(72.4)	(52.4)
Бусад нэр заагдаагүй орлого	510.0	690.3	510.0	690.3	1,358.1	667.8	848.1
Хүлээгдэж буй орлого		250.0		591.8		(250.0)	-

Сангийн сайдын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-аар татвар төлөгчийн төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах харилцааг зохицуулсан.

Аймгийн татварын хэлтсийн төвлөрсөн төсвийн татварын төлөвлөгөөнд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2021 оны төлөвлөгөө 528.9 сая, гүйцэтгэл 668.3 сая төгрөг, 2022 оны төлөвлөгөө 600.0 сая төгрөг байна.

Аймгийн орон нутгийн төсвийн 2022 оны суурь орлогын төлөвлөгөөнд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 560.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан нь үндэслэлгүй буюу улсын төвлөрсөн төсөвт оруулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 93.3 хувиар тооцож төлөвлөсөн байна.

Малд ногдуулах татварын 2022 оны төлөвлөлтийг сум бүрээр малын тоо, толгойгоор авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №4 Сумуудын малд ногдуулах татварын төлөвлөлт

сая төгрөгөөр

Сумын нэр	2021 оны мал тооллогын дүн	2022 оны малд ногдуулах татварын төлөвлөгөө	Сумын нэр	2021 оны мал тооллогын дүн	2022 оны малд ногдуулах татварын төлөвлөгөө
Алтай	164,278	0	Ногооннуур	232,146	0
Алтанцөгц	149,804	0	Сагсай	179,277	0
Баяннуур	153,060	0	Толбо	193,741	30.5
Бугат	138,433	0	Улаанхус	221,032	0
Булган	140,610	0	Цагааннуур	27,984	0
Буянт	132,259	90.0	Цэнгэл	305,039	0
Дэлүүн	270,626	90.0	Өлгий	-	0
Дүн				2,308,289	210.5

Эх сурвалж: Сумуудын малын татварын төлөвлөлтийн судалгаа

Буянт, Дэлүүн, Толбо сумууд малд ногдуулах татвараас орох орлогыг төлөвлөж сумын ИТХ-ын тогтоолоор ямар арга хэмжээнд зарцуулах талаар батлуулж ажилласан байна. Бусад сумууд малд ногдуулах татварын хэмжээг тогтоосон боловч татварын орлогыг төлөвлөж сумын ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй байна.

Сумууд малын татвараас орох орлогыг бүрэн төлөвлөж, сумын ИТХ-ын тогтоолоор батлуулж ажиллаагүйгээс малын татварын ногдуулалт, төвлөрүүлэлт хангалтгүй байна.

Аудитын дүнгээр сумуудын ИТХ, Засаг дарга нарт малын татвараас орох орлогыг төлөвлөж, сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлэх замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг үндэслэлтэй төлөвлөх талаар аймгийн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст зөвлөмж хүргүүлэв.

Аймгийн ИТХ-ын 93 дугаар тогтоолоор сумуудын татварын болон татварын бус орлогыг анх баталснаас 251.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож баталсан ба сумууд 1,206.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт №5 Төсвийн суурь орлогын төлөвлөлт /сумуудаар/

сая төгрөгөөр

№	Сумын нэр	2022 он				
		Анх баталсан	Тодотгосон төлөвлөгөө	Сумууд нэмж баталсан	зөрүү	
		1	2	3	/2-1/	/3-2/
1	Алтай	434.6	436.0	480.2	1.4	44.1
2	Алтанцөгц	216.5	227.2	227.2	10.7	0.0
3	Баяннуур	288.6	286.4	286.4	-2.2	0.0
4	Бугат	340.8	348.3	356.0	7.5	7.7
5	Булган	504.0	508.1	508.1	4.1	0.0
6	Буянт	287.7	291.2	381.2	3.5	90.0
7	Дэлүүн	556.5	556.1	852.5	-0.4	296.4
8	Ногооннуур	394.0	402.0	413.8	8.0	11.8
9	Сагсай	460.0	460.4	460.4	0.4	0.0
10	Толбо	372.7	377.5	408.0	4.8	30.5
11	Улаанхус	540.2	547.5	675.5	7.3	128.0
12	Цэнгэл	559.7	561.0	702.9	1.3	141.9
13	Цагааннуур	354.8	364.5	399.5	9.7	35.0
14	Өлгий	6949.9	7144.8	7565.9	194.9	421.1
15	Татварын хэлтэс	2681.7	2636.0	2476.0	-45.7	-160.0
	БҮГД	14941.7	15147.2	16193.6	205.5	1046.5
	Аймгийн дүн	2681.7	2636.0	2476.0	-45.7	-160.0
	Сумуудын дүн	12260.0	12511.2	13717.7	251.2	1206.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын баталсан төлөвлөгөөнөөс Алтай, Бугат, Буянт, Дэлүүн, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум болон Цагааннуур тосгон 7.7-296.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Ногооннуур сум 3.0 сая, аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөг 160.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн төсвийн суурь орлогын төлөвлөлтөөр Ногооннуур сумын ИТХ-ын тогтоолоор баталсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг 14.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэж тайлагнасан, Э цахим тайланд зөрүүтэй оруулсныг залруулав.

1.1.2. Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөлт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 51 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн нийт орлогыг 36,517.7 сая төгрөгөөр, МУ-ын 2022 оны төсвийн хуульд орсон өөрчлөлтөөр 29,173.2 сая төгрөгөөр, аймгийн 2022 оны төсөвт хийсэн тодотгол болон сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмж баталснаар тус аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн нийт орлого эх үүсвэрийг 35,469.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тус аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 1,534.4 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 5,810.0 сая, нийт 7,344.5 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн

ээлжит VIII хуралдааны “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 93 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн суурь орлогыг 1,739.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 15,147.2 сая төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 8,776.3 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 6,989.6 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 122.4 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих орлогыг 381.0 сая, нийт 31,416.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна. Энэ нь анх баталсан төсвөөс 5,101.2 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.

Сумуудын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор баталснаас 7,358.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 35,469.9 сая төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №6 Төсвийн нийт орлогын төлөвлөгөө

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2021 оны нийт орлого, эх үүсвэр	2022 оны төсвийн нийт орлого, эх үүсвэрийн төлөвлөлт				
		Анх баталсан	МУ-ын 2022 оны төсвийн хуульд орсон өөрчлөлтөөр	Аймгийн ИТХ-ын 93 дугаар тогтоолоор тодотгосон	Сумуудын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлсэн	Зөрүү
Татварын орлого	11932.4	13199.0	12334.9	13135.0	14090.8	891.8
Татварын бус орлого	1472.4	1742.7	1072.4	2012.1	2102.8	360.1
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	6451.8	14586.3	8776.3	8776.3	8776.3	-5810.0
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	8360.3	6989.6	6989.6	6989.6	6793.4	-196.2
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	66926.8	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	419.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1329.9	0.0	0.0	122.4	1771.5	1771.5
Туслах үйл ажиллагааны орлогоос	29.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	750.1	0.0	0.0	381.0	1551.9	1551.9
Төсвийн шилжих үлдэгдэл	0	0.0	0.0	0.0	383.2	383.2
Нийт орлогын дүн	97672.5	36517.7	29173.2	31416.5	35469.9	-1047.8

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд 4 удаа тодотгол хийж өөрчлөлт оруулсан байна.

1.2.1 Орон нутгийн төсвийн суурь зарлагын төлөвлөлт

Сангийн яамнаас тус аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг 28,053.8 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор Сангийн яамнаас хянасан төсвийн зарлагын төлөвлөгөөг 1,879.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тус аймгийн

орон нутгийн төсвийн суурь зарлагыг анх баталснаас 7,344.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Зардлын бүлгээр авч үзэхэд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 431.3 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 2,520.8 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 190.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 3,288.4 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 704.3 сая төгрөгөөр бусад зардлын бүлгийг 13.4-190.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

ТЗШ-ийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг 5 дугаар сарын 01-нээс улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг бууруулж өөрчлөлт оруулсан байна.

Төсөв батлах үеэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих болсонтой холбоотой Эрүүл мэндийн яамнаас санхүүжих болж байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг өөрчилж баталсан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг яамнаас санхүүжүүлэх болсонтой холбоотой бууруулж баталсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс бусад бараа үйлчилгээний зардлуудыг бууруулж баталсан байна.

Хүснэгт №7 Орон нутгийн суурь зарлагын төлөвлөгөө

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан	Анх баталсан	МУ-ын Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтө өр	Аймгийн ИТХ-ын тогтооло ор тодотгож баталсан	Зөрүү	
А	1	2	3	4	/3-2/	/4-3/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28053.7	29932.9	22588.5	24831.8	-7344.5	2243.3
УРСГАЛ ЗАРДАЛ	27152.9	29032.1	21687.7	23931.0	-7344.5	2243.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26077.2	27951.3	20648.0	22975.8	-7303.4	2327.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5305.57	5,827.84	5,446.32	6430.0	-381.5	983.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	665.58	733	683.18	825.0	-49.8	141.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5575.59	8094.48	5573.7	6895.5	-2520.8	1321.8
Хангамж, бараа материалын зардал	305.73	402.52	287.38	421.0	-115.1	133.7
Нормативт зардал	222.5	222.5	209.15	222.4	-13.4	13.3
Эд хогшил, урсгал засварын зардал	70.9	260.62	70.6	227.4	-190.0	156.8
Томилолт, зочны зардал	67.59	103.5	63.5	110.7	-40.0	47.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12038.13	9782.19	6493.77	5135.1	-3288.4	-1358.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1825.56	2524.6	1820.3	2708.7	-704.3	888.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1075.79	1080.79	1039.7	955.2	-41.1	-84.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	900.8	900.8	900.8	900.8	0.0	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28053.8	29932.9	22588.5	24831.8	-7344.4	2243.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих	28001.4	29860.5	22536.1	24328.3	-7324.4	1792.3

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн төсвөөс санхүүжих	28001.35	29455.7	22131.2	23923.5	-7324.4	1792.3
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		404.8	404.9	404.9	0.1	0.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	52.4	72.41	52.41	503.46	-20.0	451.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52.4	72.41	52.41	122.5	-20.0	70.1
Урьд оны үлдэгдлээс				381.0	0.0	381.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 93 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг 2,243.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 24,831.8 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Зардлын бүлгээр авч үзвэл: Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 1,125.4 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1,321.8 сая, хангамж бараа материалын зардлыг 133.7 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 156.8 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 888.3 сая төгрөгөөр бусад зардлын бүлгийг 13.3-133.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,358.7 сая төгрөгөөр бууруулж тодотгож баталсан байна.

Засгийн газрын 192, 193 дугаар тогтоолоор төрийн албан хаагч нарын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг нэмэгдүүлж тодотгосон байна.

Соёлын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг улсын төсвөөс санхүүжих болсонтой холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг бууруулж өөрчлөлт оруулсан байна

1.2.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 6,989.6 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс 404.9 сая төгрөг нь ОНХС-аас санхүүжих суурь зарлага байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор ОНХС-аас аймгийн ОНХС-д хуваарилсан орлогын шилжүүлгээс сумуудын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3,545.6 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-ийн төсвийг 3,039.1 сая төгрөгөөр, ОНХС-аас санхүүжих суурь зардлыг 404.9 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 6,414.3 сая төгрөгөөр баталсан ба үүний 404.9 сая төгрөг нь ОНХС-аас санхүүжих суурь зарлага байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 93 дугаар тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумуудын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3,258.1 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-ийн төсвийг 2,751.4 сая төгрөгөөр, ОНХС-аас санхүүжих суурь зарлагыг 404.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51

дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр анх баталсан 137 төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2022 оны 3 дугаар сарын 28-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор 17 төсөл, арга хэмжээг хассан.
- 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 93 дугаар тогтоолоор дахин 19 төсөл, арга хэмжээг нэмсэн.
- 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 99 дугаар тогтоолоор 1 төсөл, хэмжээг бууруулсан.
- 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 120 дугаар тогтоолоор зохицуулалт хийсэн байна.

Дээрх байдлаар аймгийн ОНХС-гийн төсөвт нэг жилийн дотор 4 удаа тодотгол хийж төсөл арга хэмжээний жагсаалтыг өөрчилж, зохицуулалт хийж баталсан нь төлөвлөлт үндэслэл муутай хийгдэж байсантай холбоотой байна.

Аудитын дүнгээр Аймгийн Засаг даргад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөх талаар зөвлөмж хүргүүлэв.

1.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит VIII дугаар хуралдааны 93 дугаар тогтоолын хавсралтаар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 18 их засварын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 1050.0 сая төгрөгөөр төлөвлөж, тайлант онд санхүүжих дүнг 900.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс: 15 төсөл арга хэмжээг тайлант онд, 3 төсөл арга хэмжээг 2022-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 18 төсөл арга хэмжээнүүд нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан ба Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцсэн байна.

1.2.4 Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт

Сангийн яамнаас тус аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг 28,053.8 сая төгрөгөөр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг оруулж тооцоход аймгийн ТЭЗ-ийн 2022 оны төсвийн зарлагын нийт төлөвлөгөөг 35,043.4 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор Сангийн яамнаас хянасан төсвийн зарлагын төлөвлөгөөг 1,474.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 36,517.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймаг, сумуудын ИТХ-ын тогтоолоор төсвийн нийт зарлагын төлөвлөгөөг анх баталснаас 1,047.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 35,469.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Хүснэгт№8 **Орон нутгийн төсвийн нийт зарлагын төлөвлөлт** сая төгрөгөөр

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан	Анх баталсан	МУ-ын Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр	Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор тодотгож баталсан	Зөрүү	
А	1	2	3	4	/3-1/	/4-2/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35043.3	36517.7	28597.9	35469.9	(6,445.4)	(1,047.8)
УРСГАЛ ЗАРДАЛ	27152.9	29032.1	21687.7	33511.0	(5,465.2)	4,478.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26077.2	27951.3	20648.0	25987.6	(5,429.1)	(1,963.8)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5305.57	5,827.84	5,446.32	10480.2	140.8	4,652.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	665.58	733	683.18	1256.7	17.6	523.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5575.59	8094.48	5573.7	6927.4	(1.9)	(1,167.1)
Хангамж, бараа материалын зардал	305.73	402.52	287.3	567.9	(18.4)	165.4
Нормативт зардал	222.5	222.5	209.1	212.0	(13.4)	(10.5)
Эд хогшил, урсгал засварын зардал	70.9	260.62	70.8	307.2	(0.1)	46.6
Томилолт, зочны зардал	67.59	103.5	63.5	147.1	(4.1)	43.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12038.13	9782.19	6493.77	542.2	(5,544.4)	(9,240.0)
Бараа үйлчилгээний бусад зардал	1825.56	2524.6	1820.3	5546.8	(5.2)	3,022.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1075.79	1080.79	1039.7	7523.4	(36.1)	6,442.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,890.4	7,485.6	6,910.2	1958.9	(980.2)	(5,526.6)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35043.4	36517.7	28597.9	35469.9	(6,445.4)	(1,047.8)
Орон нутгийн төсвөөс санхүүжих	34991.0	36445.3	28545.5	32146.5	(6,445.4)	(4,298.8)
Орон нутгийн төсвөөс санхүүжих	28001.35	29455.7	22131.2	25353.1	(5,870.1)	(4,102.6)
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	6989.6	6989.6	6414.3	6793.4	(575.3)	(196.2)
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	52.4	72.41	52.41	3323.4	0.0	3,251.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52.4	72.41	52.41	1771.5	0.0	1,699.1
Урьд оны үлдэгдлээс				1551.9	-	1,551.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар тус аймгийн 2022 оны төсвийг анх баталснаас 6,445.4 сая төгрөгөөр бууруулж өөрчлөлт оруулсан байна. ТЗШ-ийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг 5 дугаар сарын 01-нээс улсын төсвөөс санхүүжүүлэх болсон, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардал болон эрүүл мэндийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагч нарын цалинг яамнаас санхүүжүүлэх болсонтой холбоотой бууруулж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 51 дүгээр тогтоолоор баталсан 2022 оны анх баталсан төсвийг аймгийн ИТХ-ын 93 дугаар тогтоолоор баталсан тодотгосон төсөвтэй харьцуулахад байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 1,167.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9,240.0 сая, хөрөнгийн зардлыг 5,526.6 сая, нормативт зардлыг 10.5 сая төгрөгөөр тус тус бууруулж, цалин хөлс болон нэмэгдэл

урамшил, НДШ-ийн зардлуудыг 5,176.1 сая, хангамж, бараа материалын зардлыг 165.4 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 46.6 сая, томилолт зочны зардлыг 43.6 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,022.2 сая, урсгал шилжүүлгийг 6,442.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/1034 тоот захирамжаар Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42.1, 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалтуудыг үндэслэн орон нутгийн байгууллагуудын 2022 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж зарим байгууллагуудын төсөвт өөрчлөлт оруулж баталсан байна.

1.3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРОН ТООНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагууд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

1.3.1 Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагуудын орон тооны төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор аймгийн ТЕЗ-ийн харъяа 35 байгууллагын орон тоог 492 хүнээр баталсан байна.

Өмнөх оны гүйцэтгэлээр орон нутгийн байгууллагуудын орон тоо хэтрэлттэй байсан. Энэ нь ТҮ-1-3 шатлалаар цалинждаг төрийн үйлчилгээний албан хаагч нарын орон тоог 51 дүгээр тогтоолд тусгаагүй байсантай холбоотой.

Сумдын ЗДТГ болон Цагааннуур тосгоны захирагчийн албаны дээрх төрийн үйлчилгээний албан хаагч нарын орон тоог Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 93 дугаар тогтоолоор дээрх орон тоог 110-аар нэмэгдүүлж 602 орон тоогоор баталсан байна.

Өлгий сумын ЗДТГ-ын орон тоог 5-аар бууруулж, сумуудын ЗДТГ-ын орон тоог 88, Цагааннуур тосгоны захирагчийн албаны орон тоог 10, аймгийн ИТХ-ын орон тоог 6, Орон нутгийн өмчийн газрын орон тоог 5, Асрамжийн газрын орон тоог 6 орон тоогоор нийт 110 орон тоогоор нэмэгдүүлсэн байна.

БОАЖГ нь 44 орон тоогоор ажиллаж байгаа боловч Аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтад 2021 онд 44, 2022 онд 39 орон тоогоор тусгаж 5 орон тоогоор алдаатай оруулсан байна.

Аймгийн ИТХ, сумуудын ИТХ-ын орон тоог Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолыг баримтлан төлөвлөсөн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ЗДТГ-ын орон тооны хязгаарыг Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 267 дугаар тогтоолыг баримтлан ажиллах талаар анхааруулсан боловч Өлгий сумын ЗДТГ, Цагааннуур тосгоны захирагчийн алба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд орлогын давсан хэсэг болон орон нутгийн орлогыг нэмж цалингийн сан бүрдүүлж шинээр орон тоо бий болгож ажилласан байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ**

Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөө 555.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

2.1.1 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө 16,193.6 сая төгрөг ба гүйцэтгэлээр 16,749.3 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 3.4 хувиар буюу 555.7 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Татварын буцаан олголтыг нэмж тооцоход нийтдээ 17,671.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Татварын орлогын төлөвлөгөө 784.4 сая төгрөгөөр давж биелсэн бол татварын бус орлогын төлөвлөгөө 228.8 сая төгрөгөөр тасарсан байна.

*Хүснэгт№9 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл**сая төгрөгөөр*

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
СУУРЬ ОРЛОГО	16,193.6	16,749.3	555.7
УРСГАЛ ОРЛОГО	16,193.6	16,749.3	555.7
ТАТВАРЫН ОРЛОГО	14,090.8	14,875.2	784.4
Орлогын албан татвар	10,298.4	10,525.1	226.7
ХАОАТатвар	10,298.4	10,525.1	226.7
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	8,408.5	9,723.2	1,314.7
Үйл ажиллагааны орлого	1,010.0	508.0	(502.0)
Хөрөнгийн орлого	1,555.0	1,005.5	(549.5)
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	240.0	210.4	(29.6)
ХХОАТатварын буцаан олголт	(915.1)	(922.1)	(7.0)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560.0	448.0	(112.0)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560.0	448.0	(112.0)
Хөрөнгийн албан татвар	1,195.5	1,253.5	58.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	420.0	322.9	(97.1)
Бууны албан татвар	65.0	53.8	(11.2)
АТӨЯХАТатвар	500.0	577.4	77.4
Малд ногдуулах татвар	210.5	299.4	88.9
Бусад татвар, төлбөр, хураамж	549.0	718.8	169.8
Улсын тэмдэгтийн хураамж	345.0	626.1	281.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	60.0	75.3	15.3
Ус бохирдлын төлбөр, хураамж	5.0		(5.0)
Хог хягдалын үйлчилгээний хураамж	139.0	17.4	(121.6)
Газрын төлбөр	320.0	216.0	(104.0)
Газрын төлбөр	320.0	203.6	(116.4)
Дуудлага худалдаа		12.4	12.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	999.6	1,713.9	714.3

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	48.0	59.8	11.8
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	931.6	1,641.5	709.9
Ус, рашаан ашигласны төлбөр	20.0	12.5	(7.5)
Бусад татвар	168.3	-	(168.3)
Бусад татвар	168.3		(168.3)
II.Татварын бус орлого	2,102.8	1,874.0	(228.8)
Хүүгийн орлого	736.0	333.1	(402.8)
Торгуулийн орлого	8.8	515.2	506.4
Бусад нэр заагдаагүй орлого	1,358.1	1,025.7	(332.4)

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл: Татварын орлогоос цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 1,314.7 сая, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 77.4 сая, улсын тэмдэгтийн хураамж 281.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 15.3 сая, дуудлага худалдааны орлого 12.4 сая, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 11.8 сая төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 709.9 сая төгрөгөөр, татварын бус орлогоос торгуулийн орлого 506.4 сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

Үйл ажиллагааны орлого 502.0 сая, хөрөнгийн орлого 549.5 сая, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 29.6 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 112.0 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 97.1 сая, бууны албан татвар 11.2 сая, ус бохирдлын төлбөр, хураамж 5.0 сая, хог хаягдлын үйлчилгээний хураамж 121.6 сая, газрын төлбөр 116.4 сая, ус, рашаан ашигласны төлбөр 7.5 сая, бусад татвар 168.3 сая төгрөгөөр, татварын бус орлогоос хүүгийн орлого 402.8 сая, бусад нэр заагдаагүй орлого 332.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн СТСХ, аймгийн Татварын хэлтсийн тооцоо нийлсэн татварын орлогын гүйцэтгэлийн мэдээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын байдлаар 133.3 сая төгрөг байна.

Сангийн яамнаас орлогын биелэлт, нөхцөл байдал болон зарим аймгийн хүсэлтийг харгалзаж 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос урьдчилан 2022 онд авч, санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор тайлагнах чиглэл ирүүлсэн байна. Тус аймагт 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 314.7 сая төгрөгийг урьдчилан олгосон байна.

Зарим төрлийн татварын орлогын төлөвлөгөө тасарсан нь аймаг, сумын хэмжээнд татварын орлогын төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн, татварын орлогыг төвлөрүүлэх ажил хангалтгүй хийгдсэн гэж үзэх үндэстэй байна.

Сумуудын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 222.1 сая төгрөгөөр, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 333.6 сая төгрөгөөр буюу нийтдээ 555.7 сая төгрөгөөр давж биелэгджээ.

Хүснэгт №10 **Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл / сумаар/**

сая төгрөгөөр

№	Сумын нэр	2022 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Алтай	480.2	519.9	39.8	108.3

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

2	Алтанцөгц	227.2	228.6	1.4	100.6
3	Баяннуур	286.4	273.0	(13.4)	95.3
4	Бугат	356.0	333.8	(22.2)	93.8
5	Булган	508.1	636.9	128.8	125.4
6	Буянт	381.2	308.4	(72.9)	80.9
7	Дэлүүн	852.5	864.0	11.5	101.3
8	Ногооннуур	413.8	737.0	323.2	178.1
9	Сагсай	460.4	718.0	257.6	156.0
10	Толбо	408.0	374.5	(33.6)	91.8
11	Улаанхус	675.5	798.7	123.2	118.2
12	Цэнгэл	702.9	720.5	17.6	102.5
13	Цагааннуур	399.5	377.7	(21.8)	94.5
14	Өлгий	7,565.9	7,048.8	(517.1)	93.2
15	Татварын хэлтэс	2,476.0	2,809.6	333.6	113.5
	БҮГД	16,193.6	16,749.3	555.7	103.4
	Сумын дүн	13,717.6	13,939.7	222.1	101.6
	Аймгийн дүн	2,476.0	2,809.6	333.6	113.5

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай сум 39.8 сая, Алтанцөгц сум 1.4 сая, Булган сум 128.8 сая, Дэлүүн сум 11.5 сая, Ногооннуур сум 323.2 сая, Сагсай сум 257.6 сая, Улаанхус сум 123.2 сая, Цэнгэл сум 17.6 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Баяннуур сум 13.4 сая, Бугат сум 22.2 сая, Буянт сум 72.9 сая, Толбо сум 33.6 сая, Цагааннуур тосгон 21.8 сая, Өлгий сум 517.1 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

2.1.2 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл

Баян-Өлгий аймгийн 2022 оны төсвийн нийт орлого, тусламж, эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөө 35,469.9 сая төгрөг байна. Гүйцэтгэлээр нийтдээ 32,828.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 7.5 хувь бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №11 Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2021 оны нийт орлого, эх үүсвэр	2022 оны төсвийн орлогын			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	11932.4	14090.8	14875.2	784.4	105.6%
Татварын бус орлого	1472.4	2102.8	1874.0	-228.8	89.1%
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	6451.8	8776.3	8776.3	0.0	100.0%
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	8360.3	6793.4	6361.4	-432.0	93.6%
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	66926.8	0.0	0.0	0.0	0.0%
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	419.4	0.0	0.0	0.0	0.0%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1329.9	1771.5	916.0	-855.5	51.7%
Туслах үйл ажиллагааны орлогоос	29.4	0.0	25.6	25.6	0.00%
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	750.1	1551.9	0.0	-1551.9	0.0%
Төсвийн шилжих үлдэгдэл		383.2		-383.2	0.0
Нийт орлогын дүн	97672.5	35469.9	32828.6	-2641.3	92.55

Эх сурвалж: Орон нутгийн орлогын судалгаа

Төсвөөс авсан санхүүжилтээс орон нутгийн төсвийн байгууллагууд оны эцэст 323.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Орлогын гүйцэтгэлийг задалж авч үзвэл:

Орон нутгийн төсвийн суурь орлогын гүйцэтгэлээр нийтдээ 16,749.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс 8,776.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр 6,361.4 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 916.0 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөснөөс 855.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан. Туслах үйл ажиллагааны орлогоос 25.6 сая төгрөгийн орлого оруулсан.

Сангийн сайдын тушаалаар Азийн хөгжлийн банкны орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын чадавхыг сайжруулах төслийн хүрээнд орон нутгийн өмчийн “Суат” ХХК-д 2002 онд хэрэгжсэн төслийн урт хугацаат 991.1 сая төгрөгийн зээлийн төлбөрт 331.0 сая, хүүгийн төлбөрт 33.9 сая, нийт 364.9 сая төгрөгийг аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс суутган төлүүлсэн байна.

Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс суутгаж авсан 364.9 сая төгрөгийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Суат” ХХК-аас авлагаар тусгаж, “Суат” ХХК-ны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнасан байна.

2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөөний биелэлт 91.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл

Аймгийн 2022 оны оны нэгдсэн төсвийн зарлагын батлагдсан нийт төлөвлөгөө 35,469.9 сая төгрөг ба гүйцэтгэлээр 32,435.0 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, төлөвлөснөөс 3,034.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт №12 Нийт төсвийн зарлагын гүйцэтгэл

сая төгрөгөөр

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны			Зөрүү өмнөх оны гүйцэтгэл
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
А	1	2	3	/3-2/	/3-1/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95523.5	35469.9	32,435.0	-3034.9	-63088.5
УРСГАЛ ЗАРДАЛ	87989.9	33511.0	31,137.1	-2373.9	-56852.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84707.7	25987.6	24,479.4	-1508.2	-60228.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59929.2	10480.2	10,389.1	-91.1	-49540.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8037.9	1256.7	1,253.2	-3.4	-6784.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5608.9	6927.4	6,824.3	-103.1	1215.4

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Хангамж, бараа материалын зардал	1437.2	567.9	552.3	-15.6	-884.9
Нормативт зардал	3292.8	212.0	211.1	-1.0	-3081.7
Эд хогшил, урсгал засварын зардал	683.4	307.2	289.0	-18.2	-394.4
Томилолт, зочны зардал	161.1	147.1	139.3	-7.8	-21.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	928.5	542.2	465.4	-76.9	-463.2
Бараа үйлчилгээний бусад зардал	4628.7	5546.8	4,355.7	-1191.1	-273.0
Татаас	1342.4	0.0	-	0.0	-1342.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1342.4			0.0	-1342.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1939.8	7523.4	6,657.7	-865.7	4717.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7533.6	1958.9	1,297.9	-661.0	-6235.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96736.1	35469.9	32,631.8	-2838.1	-64104.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67346.2	0.0	-	0.0	-67346.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	66926.8			0.0	-66926.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас	419.4			0.0	-419.4
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27963.7	32146.5	31,690.4	-456.1	3726.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих	19603.4	25353.1	25,329.0	-24.1	5725.6
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	8360.3	6793.4	6,361.4	-432.0	-1998.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1426.2	3323.4	941.4	-2382.0	-484.8
				0	0
Мөнгөний эхний үлдэгдэл	914.9		2,151.2		
Мөнгөний эцсийн үлдэгдэл	2127.4		2,348.0		

Эх сурвалж: Аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нийт зарлагын 24,479.4 сая төгрөгийг буюу 75.5 хувийг бараа үйлчилгээний зардалд, 6,657.7 сая төгрөгийг буюу 20.5 хувийг урсгал шилжүүлэгт, 1,297.9 сая төгрөгийг буюу 4 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөвтэй харьцуулахад бараа үйлчилгээний зардал 1,508.2 сая, урсгал шилжүүлэг 865.7 сая, хөрөнгийн зардал 661.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Тайлант оны зарлагын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 63,088.5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь 2022 оноос тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой.

Аймгийн ТЕЗ-ийн ирүүлсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аймагт төвлөрүүлэх тэгшитгэлийг оруулж 3,000.6 сая төгрөгөөр илүү буюу 35,435.6 сая төгрөгөөр тайлагнаж ирүүлснийг төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулга хийлгэв.

Төсвийн гүйцэтгэлийг байгууллагаар авч үзвэл бүх байгууллагууд төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумуудын Хоршоог хөгжүүлэх сангууд нийт дүнгээр 741.6 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь бүх сумуудын зээлийн төлбөрөөс төвлөрүүлэх орлого тасарсантай холбоотой. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дутуугаас санхүүжилтийг олгоогүй байгаатай холбоотой байна.

Хүснэгт №13 Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг байгуулгаар харуулбал

сая төгрөгөөр

Байгууллага	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Сумуудын ЗДТГ	7,254,781,800.0	7,154,388,461.2	-100,393,338.8
Сумуудын ИТХ	1,328,099,300.0	1,099,591,647.5	-228,507,652.6
Аймгийн ОНХС	2,988,422,100.0	2,513,915,105.0	-474,506,995.0
Сумуудын ОНХС	4,259,056,300.0	3,601,967,482.4	-657,088,817.6
Орон нутгийн хөрөнгө оруулалт	900,783,100.0	560,537,850.0	-340,245,250.0
Сум хөгжүүлэх сан	1,644,730,600.0	903,094,300.0	-741,636,300.0
БОХСан	10,753,000.0	10,199,760.0	-553,240.0
ЕБ-ын байгууллагуудын тогтмол зардал	5,926,780,300.0	5,849,859,201.0	-76,921,099.0
СӨБ-уудын тогтмол зардал	2,419,180,300.0	2,391,549,834.8	-27,630,465.2
ЭМТ-үүдийн Тогтмол зардал	425,015,100.0	414,778,531.0	-10,236,569.0
Соёлын төвүүдийн тогтмол зардлууд	411,169,200.0	389,286,407.8	-21,882,792.2
Хот тохижуулах албан	177,461,300.00	177,461,300.00	0.0
Аймгийн шууд	7,723,677,700.0	7,368,388,711.6	-355,288,988.4
ДҮН	35,469,910,100.0	32,435,018,592.3	-3,034,891,507.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн төсвийн байгууллагууд тайлант онд батлагдсан төсвийг 820.8 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

2.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд 6,361.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс 404.5 сая төгрөг урсгал зардалд баталсан төсөв байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгосон орлогын шилжүүлгийн 6,361.4 сая төгрөг болон аймаг, сумын ИТХ ын тогтоолоор урьд оны үлдэгдлээс тодотгож баталсан 514.6 сая төгрөг, нийт 7,247.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж гүйцэтгэлээр 6,115.8 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Сумуудын ОНХС-гийн батлагдсан төлөвлөгөө 4,259.0 сая, гүйцэтгэл 3,601.9 сая төгрөг байна. Аймгийн ОНХСангийн батлагдсан төлөвлөгөө 2,988.4 сая, гүйцэтгэл 2,513.9 сая төгрөг байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 138 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2,513.9 сая төгрөгийн 133 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн ба 169.2 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн боловч материалаа ирүүлээгүй тул санхүүжилт олгогдоогүй байна. Он дамжин 2022-2023 онд хэрэгжих 27.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, 2022 онд хэрэгжих 9.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шууд гэрээ байгуулсан 8, харьцуулалтын аргаар хэрэгжүүлсэн 7, нийт 15 төсөл, арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулсан 3 төсөл арга хэмжээний 1 төсөл арга хэмжээ нь 76.7 хувийн гүйцэтгэлтэй, 2 төсөл арга хэмжээ нь гэрээг хугацаа хожимдож хийсний улмаас хэрэгжээгүй байна.

Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажил нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ бөгөөд гэрээнд заасан ажлыг бүрэн хийж, 76.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны 75 Б корпусын засварын ажлыг 133.9 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг 2022 оны 12 дугаар сарын 07-нд, Цэнгэл сумын Загаст нуур багийн дотуур байрны барилгыг сургуулийн зориулалттай болгож засварлах ажлыг 150.0 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг 2022 оны 12 дугаар сарын 14-нд байгуулснаас шалтгаалан тайлант онд хэрэгжээгүй байна.

Тайлант онд олгох 684.1 сая төгрөгийн гэрээний дүнгээс гүйцэтгэлээр 560.5 төгрөгийн санхүүжилт олгож, 123.3 сая төгрөгийн санхүүжилтийг он гаргаж олгосон байна.

2.2.4 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тооны гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан орон тооны хязгаар 602, гүйцэтгэл 602 байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудад удирдах 155, гүйцэтгэх 296, үйлчлэх 108, гэрээт 43 орон тоо ажилласан байна.

Хүснэгт №14 **Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл**

Байгууллагууд	Ажиллагсдын тоо							
	Өмнөх оны гүйцэтгэл	2022 оны						Гэрээт
		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Удирдах	Гүйцэтгэх	Үйлчлэх	
Орон нутгийн байгууллагууд	607	602	602	0	155	296	108	43

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.2.5 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Орон нутгийн төсвийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд оны эхэнд 4.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 3,211.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч үүнээс 2,118.4 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 1,097.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогын 35.3 сая төгрөгийг буюу 1.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс авсан хандив, тусламжаас, 98.6 сая төгрөгийг буюу

3.1 хувийг ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс хуваарилсан хөрөнгөнөөс, 2,802.4 сая төгрөгийг буюу 87.3 хувийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс, 275.0 сая төгрөгийг буюу 8.5 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос хүлээн авсан байна.

Хүснэгт №15 **Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл**
(сая төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,096.10	2,118.42
УРСГАЛ ЗАРДАЛ	2,923.31	2,110.07
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,282.19	1,404.84
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	619.00	76.73
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68.10	1.94
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39.66	2.18
Хангамж, бараа материалын зардал	173.03	53.88
Нормативт зардал	253.21	9.26
Эд хогшил, урсгал засварын зардал	63.78	5.43
Томилолт, зочны зардал	16.39	29.91
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22.25	15.59
Бараа үйлчилгээний бусад зардал	1,026.76	1,209.92
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	641.13	705.23
Бусад урсгал шилжүүлэг	569.11	0.50
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	72.02	704.73
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	172.79	8.35
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,088.18	3,211.29
Нэмэлт санхүүжилтийн орлого	3,088.18	3,211.29
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	93.89	35.27
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42.60	98.66
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,372.02	2,802.35
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	579.67	275.01
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(7.92)	1,092.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12.37	4.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4.46	1,097.33

Нэмэлт санхүүжилтийн 69.7 хувийг буюу 2,110.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 33.3 хувийг буюу 705.2 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт, 0.4 хувийг буюу 8.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтээс төсөвт 703.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнээс: 592.2 сая төгрөг нь Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц барих газраас Баяннуур сумын айл өрхийг шилжүүлэн суурьшуулах ажлын санхүүжилтээс төвлөрүүлсэн байна.

Бүлэг 3. Хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

3.1 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 122.6 сая төгрөгийг зөрчил гаргасан байна

Төрийн хэмнэлтийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан “Хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 203, 204 мөн 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд зарим арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг царцааж, хуваарилагдсан хөрөнгийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зарцуулах шийдвэр гарсны дагуу аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг бууруулж тодотгож баталсан байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтад зориулан улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллага, үндэсний хэмжээний төсөл хөтөлбөрийн шугамаар нийтдээ 47 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь эдийн засгийн хямралтай үед аймгийн нийгэм, эдийн засагт дэмжлэг болсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Сангийн яамнаас ирсэн чиглэлийг сумдын санхүүгийн албанд 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 5-03/1064 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд тайлант онд цалин хөлс, НДШ-ийн зардлыг 94.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 103.1 сая, хангамж, бараа материалын зардлыг 15.6 сая, нормативт зардлыг 1.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 18.2 сая, томилолт, зочны зардлын 7.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 76.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,191.1 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 865.7 сая, хөрөнгийн зардлыг 661.1 сая төгрөгөөр нийт 3,034.9 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь тэтгэвэрт гарсан 2 хүнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгож цалингийн зардлаас 1.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг давхар олгосон.
- Улаанхус сумын Засаг даргын тамгын газар нь зочин хүлээн авах зардлаас 0.1 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.
- Аймгийн Засаг даргын тамгын газар нь 15.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг цахим дэлгүүрээс бусад газраас худалдан авсан байна.
- Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь төрөл бүрийн спортын арга хэмжээ, шагналд 13.2 сая төгрөгийг зарцуулсан.

- Цахилгаан шугам сүлжээний газар нь шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 7.8 сая төгрөгийн, “Суат” ХХК нь бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 12.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 120.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгөгдсөн байна.

3.2 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшин

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний төлөвлөлт хангалтгүй байна

Тус аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 хэсгийн 54.5.1, 54.5.2, 54.5.3, 54.5.4-д заасан бүрэлдэхүүний хамт ирүүлээгүй буюу танилцуулга, тайлбар, тодруулга ирүүлээгүй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 22 арга хэмжээ байгаагаас Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2021 оны “Баян-Өлгий аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолын дугаар хавсралтаар хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, түүнд хамаарах 16 арга хэмжээ баталсан ба 6 арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшнийг дутуу баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5-д “төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах” гэсэн ба өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар баталсан боловч төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр хүрэх үр дүнг батлаагүй ба орон нутгийн гүйцэтгэх засаглалын хэрэгжүүлэх хөтөлбөрийн зарим арга хэмжээний зорилтот түвшин, хүрэх үр дүнг бодитой төлөвлөөгүй орхигдуулсан байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөр буюу аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд хамаарах 3 арга хэмжээ, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 13 арга хэмжээг баталсан байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөрт аймгийн ИТХ-ын байгууллагын үйл ажиллагаа, олон нийттэй харилцах, мэдээлэл сурталчилгаа, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлууд хамрагдаж байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, хууль, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, хяналт, шинжилгээ, ахмад настны нийгмийн хамгаалал, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, ойжуулалтын ажиллагаа, мал эмнэлгийн үйлчилгээ, замын сан, насан туршийн боловсролын үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн харилцааны талаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрэх үр дүнг төлөвлөсөн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний төлөвлөлт хангалтгүй байна. Төсвийн эрх захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн зорилтот түвшний чанарын болон тоон үзүүлэлтийг бодитой тусгаж батлаагүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн арга хэмжээнүүдээс Орон нутгийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоог хөгжүүлэх сан, хот тохижуулах ажил, хэвлэл мэдээллийн салбар болон ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлын хүрэх үр дүн, зорилтот түвшний чанарын болон тоон үзүүлэлтийг батлаагүй байна.

Орон нутгийн өөрийн удирдлага хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээ 89.9 хувь, сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээ 92.2 хувь, аймгийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн хувьд 91.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшнийг аймгийн Засаг даргын тухайн онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөртэй уялдуулж, хүрэх зорилтот түвшин, зарцуулах төсөв, чанарын үзүүлэлтийг үнэн зөв тусгаж төлөвлөх, хүрсэн үр дүн, гүйцэтгэлийг чанарын болон тоон үзүүлэлттэй харьцуулан гаргаж танилцуулга, тайлбар, дүгнэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт ирүүлж хэвших талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан тул албан шаардлага өгөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдснээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад 4 удаа өөрчлөлт оруулсан.
3. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд орон тооны батлагдсан хязгаарыг баримталж ажилласан байна.
4. Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөө 555.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.
5. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл 91.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.
6. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 122.6 сая төгрөгийг зөрчил гаргасан байна.
7. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зорилтот түвшний төлөвлөлт, тайлагнал хангалтгүй хийгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Х.АРМАН ТАНАА:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас аймгийн төсөвт орох орлогыг үндэслэлтэй төлөвлөх;
2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг үндэслэлтэй төлөвлөж батлуулах;

СУМУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах.


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/07

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг даргын орлогчид тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /Х.Арман/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Т.Фестивал/, нарт зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

D:\bichig hereg\2023\tushaal.doc